



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/28

Сүхбаатар сум

Хэвлэлтийн зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "е", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 12 тоот тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.9, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Сэлэнгэ аймгийн 2020 оны төсөв батлах тухай" 70 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймаг орон нутгийн цаг үеийн мэдээ мэдээлэл, ярилцлага, алдартан гавьяатан баялаг бүтээгчдийг таниулан сурталчлах "Өргөн Сэлэнгэ" сэтгүүлийн 2020 оны 1 дүгээр улирлын хэвлэлтэд шаардагдах 7000000 /долоон сая/ төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.
2. Хавсралтад заагдсан зардлыг аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.
3. Гаргасан мэдээ, мэдээлэлд хяналт тавьж, зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ШОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2020 оны 02 дугаар сарын 04
өдрийн А/28 тоот захирамжийн
хавсралт



“ӨРГӨН СЭЛЭНГЭ” СЭТГҮҮЛИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	“Өргөн Сэлэнгэ” сэтгүүл /2020 оны 1 дүгээр улирал/	1000 ш	7000	7.000.000
	НИЙТ ДҮН			7.000.000

Төсөв боловсруулсан  Д.Одонтунгалаг
(ХШУДАХ-ийн мэргэжилтэн)

Төсөв хянасан:



З.Загдсүрэн
(Тооны Ня-бо)